

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭСЯ	Элчин сайдын яам

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	4
2	Аудитын тайлан	6
	2.1. Оршил.....	6
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	9
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	10
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	10
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
	2.11. Шилэн дансны мэдээлэл	13
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3	Менежментийн захидал.....	15
	Зардлын данстай холбоотой асуудал	15
	3.1.1 Илрүүлэлт:.....	15
	3.1.2 Эрсдэл:	15
	3.1.3 Өгсөн зөвлөмж:	15
	3.1.4 байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	16
	3.2 Балансын данстай холбоотой асуудал.....	16
	3.2.1 Илрүүлэлт:.....	16
	3.2.2 Эрсдэл:	16
	3.2.3 Өгсөн зөвлөмж:	16
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	16
	3.3 Балансын данстай холбоотой асуудал.....	16
	3.3.1 Илрүүлэлт:.....	16
	3.3.2 Эрсдэл:	16
	3.3.3 Өгсөн зөвлөмж:	17
	3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	17

3.4	БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ.....	17
3.4.1	Илрүүлэлт:.....	17
3.4.2	Эрсдэл:	17
	Үүрэг даалгавар хэрэгжихгүй байх, хөрөнгө шамшигдах	17
3.4.3	Өгсөн зөвлөмж:	17
3.4.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	17
3.5	ПРОГРАМ ХАНГАМЖТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ	17
3.5.1	Илрүүлэлт:.....	17
3.5.2	Эрсдэл:	18
3.5.3	Өгсөн зөвлөмж:	18
3.5.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	18
4	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	19
4.1	Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	19
4.2	Аудит хийсэн ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	20
4.3	Аудит хийсэн ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	21
4.4	Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	22
5.	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	23

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/462
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР”
ТӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Ё.НЯМЖАВ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2019\0315SAG25.Docx

071169

Үүрэг, хариуцлага

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Ё.Нямжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн ДБ 05/144 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь “Олон улсын стандартын түвшинд хүрсэн найдвартай, мэргэшсэн үйлчилгээ бүхий өрсөлдөх чадвартай байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дипломат харилцааны тухай Венийн 1961 оны конвенц, олон улсын түгээмэл жишгийн дагуу тухайн улсад суугаа бусад улсын Дипломат болон Консулын төлөөлөгчийн газрууд, Олон Улсын байгууллагын хэрэгцээний газар, албаны байр олж авах, газар, байрны эзэмшил, ашиглалттай холбоотой бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах Гадаад

харилцааны яамны чиг үүргийг түүний харъяа “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус газар нь Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор ханган ажиллах үндсэн зорилго, зорилтын хүрээнд дараах нийтлэг үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын барилга байгууламж, цахилгаан, сантехникийн засвар үйлчилгээ, тохижилт;
- Монгол Улсад зохион байгуулагдаж буй Төрийн бүх түвшний айлчлал, хүндэт зочид төлөөлөгчид, Гадаад харилцааны яам, Монгол улсад суугаа Элчин сайдын яамд, Консулын газрууд, Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газрын захиалгын дагуу автомашины үйлчилгээ;
- Дипломат төлөөлөгчийн газрууд нь Төрийн тусгай хамгаалалттай объектуудад байршдаг ба Олон Улсын эрх зүйн актад тусгагдсан чиг үүргийн хүрээнд объектын бүрэн бүтэн байдал, тэдний ажиллах орчин нөхцөлийн аюулгүй ажиллагааг хуулийн хүрээнд сахин хамгаалах;
- Төрийн хэмжээний айлчлал болон Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газруудын хүсэлтээр ёслол хүндэтгэлийн хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулж, чанар, стандартын өндөр түвшинд хүрсэн зоогийн үйлчилгээгээр үйлчлэх.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын олон улсын гэрээ дипломат харилцааны тухай венийн конвенц
- Дипломат албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын багц хуулиуд

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ГҮҮК СОФТ” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Explorer 3.16” програм хангамж ашигладаг байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын дотоод хяналтын ажилтан нь 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 чиглэлээр хяналт шалгалт хэрэгжүүлэхээр хөтөлбөр боловсруулан батлуулснаас гүйцэтгэлээр 5 чиглэлээр хяналт хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажлын талаар тайлан гаргаж, бүртгэл хөтөлж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээ Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов. Энэ нь материаллаг байдлын суурийг нийт орлогын дүнгээс тооцоход их байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны нийт зардал 5,089,4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 101.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Тайлагналтай холбоотой 371.1 сая төгрөгийн,
- Нягтлан бодох бүртгэлийн бичилттэй холбоотой 10,520.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	152.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	6.8	
3	Албан шаардлага өгсөн	2	7.6	
	Дүн	10	159.5	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Зардлын данстай холбоотой асуудал

Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 0.09 сая төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргаж, кассаас олгосноор зарлагдсан, ажлын хөлснөөс суутгасан ХХОАТ 0.2 сая төгрөгийг төсөвт төлөөгүй, өглөгөөр бүртгэж тайлагнаагүй.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоох

Асуудал 2: Зардлын данстай холбоотой асуудал

Албан тушаалын болон албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах эрхгүй 2 дэд захирал, Захиргааны хэлтсийн дарга, Авто баазын дарга гэсэн 4 ажилтанд автомашин унуулж, тайлант онд 7.6 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан.

Шийдэл: Албан шаардлага өгөх

Асуудал 3: Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант хугацаанд 11 ажилтанд ээлжийн амралтын нөхөн олговрыг цалинтай давхардуулж, 6.5 сая төгрөгийн илүү цалин олгосон.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоох

Асуудал 4: Зардлын данстай холбоотой асуудал

Нийслэлийн газрын албатай газар эзэмших, ашиглах гэрээ байгуулаагүйн улмаас Монгол Улсад суугаа ДТГ-уудын болон АНУ-ын ЭСЯ-ны 2018 оны газрын түрээсийн төлбөрөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлээгүй

Шийдэл: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэсэгт тусгасан болон залруулаагүй алдаа, автомашины ашиглалтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолын дагуу тус байгууллагын үл хөдлөх хөрөнгийг үнэлэх ажлын хэсгийг ДБҮЭГ-ын Ерөнхий захирлын 2018 оны А/64 дүгээр тушаалаар байгуулж үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийж ТӨБЗГ-тай гэрээ байгуулсан Монголын мэргэшсэн үнэлгээчдийн холбооны үнэлгээчнээр хянуулж баталгаажуулсан байна.

Дахин үнэлгээгээр тус байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа 21,788 м2 талбай бүхий 6 газар, 40 ш барилга, 6 ш нийтийн эзэмшлийн зам талбайг дахин үнэлж, үр дүнг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын дагуу данс бүртгэлдээ тусгасан.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны ДБ 04/159 тоот албан бичгээр ТӨБЗГ-т Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамруулаагүй хөрөнгийн жагсаалтыг тайлбарын хамтаар хүргүүлсэн байна.

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамруулаагүй хөрөнгийн талаарх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 он төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	Зөрүү (2-1)	Хувь
А	Б	1	2	3	4
Нийт орлого	мян/төг	5,482,180.0	5,429,660.8	(52,519.2)	99.0
Үйлчилгээ, ашиглалтын орлого	мян/төг	2,804,178.0	2,606,018.1	(198,159.9)	92.9
ЭСЯ-уудын түрээсийн орлого	мян/төг	1,973,533.0	1,975,594.0	2,061.0	100.1
Зоогийн үйлчилгээний орлого	мян/төг	206,836.0	226,670.6	19,834.6	109.6
Автобаазын орлого	мян/төг	90,000.0	107,681.3	17,681.3	119.6
Бусад түрээсийн орлого	мян/төг	151,733.0	211,793.8	60,060.8	139.6
Бусад орлого	мян/төг	255,900.0	296,267.5	40,367.5	115.8
Нийт зардал	мян/төг	5,394,689.2	5,298,164.2	(96,525.0)	98.2
Үйл ажиллагааны зардал	мян/төг	4,490,879.0	5,089,413.1	598,534.1	
Үйл ажиллагааны бус зардал	мян/төг		208,751.1	208,751.1	
Үүнээс: Удирдлагын зардал	мян/төг	903,810.2	791,332.5	(112,477.7)	87.6
Татварын өмнөх ашиг	мян/төг	87,490.8	131,496.6	44,005.8	150.3
Цэвэр ашиг /алдагдал/	мян/төг	78,741.7	118,346.9	39,605.2	150.3
Нийт ажиллагсадын тоо	хүн	138.0	138.0	-	100.0
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.0		99.2
Хөрөнгө оруулалт	мян/төг	550,221.0	456,318.6	(93,902.4)	82.9
Нийт авлага	мян/төг	769,567.0	797,476.8	27,909.8	103.6
Нийт өглөг	мян/төг		57,384.5	57,384.5	
- богино хугацаат өглөг	мян/төг		57,384.5	57,384.5	

Тайлант онд зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөө 99.0 хувиар биелсэн, зардлын гүйцэтгэл 98.2 хувь буюу 96.5 сая төгрөгийн хэмнэлттэй гарч, 118.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Авлага өмнөх оноос 140.1 сая төгрөгөөр буурч, өр төлбөр өмнөх оноос 33.5 сая төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр өмнөх оноос нэмэгдсэн нь тайлант оны сүүлчээр Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар 41.9 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь байгууллагын цахим хуудас <http://dipservice.gov.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбож “Шилэн дансны тухай” хуульд заасан мэдээллийг тухай бүр бүрэн оруулж хэвшсэн байна. Тухайлбал: Төсөв гүйцэтгэл талбарт байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 134 ш орлогын, 129 ш зарлагын мэдээллийг бүрэн оруулсан боловч санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг тавиагүй байна.

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт талбарт 5 төрлийн мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь байршуулсан, бусад мэдээлэл гэсэн талбарт 3 төрлийн мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг биелүүлж, зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 85.7 хувьтай байна.

Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй боловч тайлант онд авлагыг барагдуулах талаар нэлээд арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал: 10 харилцагчтай холбоотой 200.3 сая төгрөгийн авлага ШШГГ-т ажиллагаа хийгдэж, 5 харилцагчтай холбоотой 117.4 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг шүүхийн шийдвэрээр Цагдаагийн хэлтэс эрэн сурвалжилж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу

материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Автомашинд тормозны дээд аппарат солих засварын ажлыг хүлээж авсан техникийн комиссын актад холбогдох хүмүүсээр гарын үсэг зуруулаагүй, анхан шатны дэмжих баримтын бүрдэл хангалтгүй байхад 4.5 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, үргүй зардал гарах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НБББББ-ийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 33.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсөв захирагч ТӨБЗГ-тай байгуулсан Контрактын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бусад хангамжийн материалын дансанд 18 нэр төрлийн 68.9 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ыг дагаж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн үр дүн зөрүүтэй илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Бусад хангамжийн материалын дансанд бүртгэлтэй байгаа 68.9 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж бүртгэх талаар зөвлөмж өгөх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.4 Балансын данстай холбоотой

3.4.1 Илрүүлэлт:

Ерөнхий захирлын 2018 оны А/135 дугаар тушаалаар 38.2 сая төгрөгийн эд хөрөнгийг данснаас хасахдаа устгалын акт үйлдээгүй, хаана яаж устгасан нь тодорхойгүй, Өмч хамгаалах байнгын зөвлөл акталсан хөрөнгийн устгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь Ерөнхий захирлын 2018 оны А/135 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Үүрэг даалгавар хэрэгжихгүй байх, хөрөнгө шамшигдах

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын ӨХБЗ Ерөнхий захирлын тушаалаар өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.5 Програм хангамжтай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжид засвар сайжруулалт хийлгээгүйгээс санхүүгийн тайлан зөрүүтэй татагдах, тодруулга тайлангуудыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтэх заавар"-ын дагуу бэлтгэж гаргахгүй байна

Энэ нь Сангийн сайдын 2009 оны 252 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн програм хангамжид хяналт тавих тухай журмын 2.1-д *"НББ-ийн программ нь холбогдох хууль тогтоомж, НББОУС болон холбогдох заавар журамд нийцсэн байна"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх, аж ахуйн нэгж байгууллага санхүүгийн тайлангаа Сангийн сайдын баталсан зааврын дагуу бэлтгэхгүй байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програмыг холбогдох хууль тогтоомж, НББОУС болон холбогдох заавар журамд нийцсэн байхаар засвар сайжруулалт хийлгэж, програмын ашиглалтыг сайжруулах талаар зөвлөмж өгөх

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагад танилцуулахад алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,501,285,579.95	2,412,513,509.10
1.1.2	Дансны авлага	302,100,122.72	152,915,500.43
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	39,225,022.14	13,966,787.00
1.1.4	Бусад авлага	596,265,622.44	630,594,473.67
1.1.6	Бараа материал	518,329,269.05	482,689,113.71
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,957,205,616.30	3,692,679,383.91
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,388,163,332.80	22,683,321,169.24
1.2.2	Биет бус хөрөнгө	51,088,547.96	2,624,800,356.20
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,439,251,880.76	25,308,121,525.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,396,457,497.06	29,000,800,909.35
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	22,487,224.53	56,297,993.02
2.1.1.2	Цалингийн өглөг	75,000.00	1,053,661.62
2.1.1.3	Татварын өр	1,301,887.55	
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	23,864,112.08	57,351,654.64
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,864,112.08	57,351,654.64
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	5,843,643,916.35	8,408,507,916.35
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,971,927,181.81	9,124,607,661.22
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,557,022,286.82	11,410,333,677.14
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,372,593,384.98	28,943,449,254.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,396,457,497.06	29,000,800,909.35

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,679,201,295.64	5,266,473,979.51
2	Борлуулалтын өртөг	5,320,347,485.86	5,089,413,121.22
3	Нийт ашиг(алдагдал)	(641,146,190.22)	177,060,858.29
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	79,218,094.91	157,223,128.67
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	653,214,522.85	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(7,766,783.75)	14,080,866.50
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(43,964,364.46)	(217,196,568.81)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	39,555,279.33	131,168,284.65
19	Орлогын татварын зардал	3,955,527.93	13,116,828.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	35,599,751.40	118,051,456.19

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,843,643,916.35	4,971,927,181.81	8,527,597,202.44	19,343,168,300.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(6,174,667.02)	(6,174,667.02)
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			35,599,751.40	35,599,751.40
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	5,843,643,916.35	4,971,927,181.81	8,557,022,286.82	19,372,593,384.98
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			2,735,259,934.13	2,735,259,934.13
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			118,051,456.19	118,051,456.19
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	2,564,864,000.00	4,152,680,479.41		6,717,544,479.41
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	8,408,507,916.35	9,124,607,661.22	11,410,333,677.14	28,943,449,254.71

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,644,843,018.49	6,433,294,901.42
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,160,019,033.75	3,782,158,931.80
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	100,000.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	484,723,984.74	2,651,135,969.62
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,212,254,509.63	5,078,274,178.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,346,691,480.62	1,408,631,750.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	285,854,133.00	346,531,370.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	460,907,637.17	489,362,285.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,716,981,579.41	1,839,465,209.92
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	170,410,000.92	95,980,367.07
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	147,074,175.68	433,109,543.98
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	34,190,006.00	23,105,154.48
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,050,145,496.83	442,088,496.81
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	432,588,508.86	1,355,020,723.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	247,625,799.10	443,792,794.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	142,970,344.40	66,759,699.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	104,655,454.70	377,033,095.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(247,625,799.10)	(443,792,794.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	184,962,709.76	911,227,929.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,316,322,870.19	1,501,285,579.95
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,501,285,579.95	2,412,513,509.10

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/22/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ			сая төгрөгөөр

А	3	4	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
5	8	9			
1	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 0.09 сая төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргаж, кассаас олгосноор зарлагдсан, ажлын хөлснөөс суутгасан ХХОАТ 0.2 сая төгрөгийг төсөвт төлөөгүй, өглөгөөр бүртгэж тайлагнаагүй	0.3	Төлбөрийн акт тогтоох	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
2	Албан тушаалын болон албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах эрхгүй 2 дэд захирал, Захиргааны хэлтсийн дарга, Автобаазын дарга гэсэн 4 ажилтанд автомашин унуулж тайлант онд 7.6 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан	7.6	Албан шаардлага өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
3	Тайлант хугацаанд 11 ажилтанд ээлжийн амралтын нөхөн олговорыг цалинтай давхардуулж илүү цалин олгосон	6.5	Төлбөрийн акт тогтоох	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
4	Автомашинд тормозны дээд аппарат солих засварын ажлыг хүлээж авсан техникийн комиссын актанд холбогдох хүмүүсээр гарын үсэг зуруулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байхад 4.5 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн	4.5	Зөвлөмж өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
5	Тайлант онд ер төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 33.5 сая төгрөгөөр нэмэгдсэн	33.5	Зөвлөмж өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
6	Бусад хангамжийн материал дансанд 18 нэр төрлийн 68.9 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн	68.9	Зөвлөмж өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
7	Ерөнхий захирлын 2018 оны А/135 дугаар тушаалаар 38.2 сая төгрөгийн эд хөрөнгийг данснаас хасахдаа устгалын акт үйлдээгүй, хаана яаж устгасан нь тодорхойгүй, ӨХБЗөвлөл акталсан хөрөнгийн устгах ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй	38.2	Зөвлөмж өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Хулганажав
8	Нийслэлийн газрын албатай газар эзэмших, ашиглах гэрээ байгуулаагүйн улмаас Монгол Улсад суугаа ДТГ-уудын болон АНУ-ын ЭСЯ-ны 2018 оны газрын түрээсийн төлбөрөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлээгүй		Албан шаардлага өгсөн	Ерөнхий захирал Дэд захирал	Ё.Нямжав Д.Чулуунбаатар
9	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжид засвар сайжруулалт хийлгээгүйгээс санхүүгийн тайлан зөрүүтэй татагдах, тодруулга тайлангуудыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтэх заавар"-ын дагуу бэлтгэж гаргахгүй байна		Зөвлөмж өгсөн	Ерөнхий захирал Ерөнхий нягтлан бодогч	Ё.Нямжав Б.Болдбаатар
Нийт дүн		159.5			